ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

Засгийн газрын VIII байр, Олимпийн гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14210,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41,
цахим шуудан: letter@moh.gov.mn,
цахим хуудас: http://www.moh.mn

2023.12.11 № 10-00-02/011/274

"ТООНОТ КОНСТРАКШН" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ А.БАТЦЭНГЭЛ ТАНАА

Барилга, байгууламжийн
ажлын зургийн тухай

"Тоонот констракшн" ХХК-ийн эрүүл ахуйн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ТК50/2023 дугаартай албан хүсэлтийн дагуу "Сүхбаатар аймгийн Уулбаян суманд баригдах Төрийн банкны тооцооны төвийн барилгын ажлын зураг Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн эрүүл ахуйн хяналт хийлээ.

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн боловсруулалт, зориулалт:

Сүхбаатар аймгийн ерөнхий архитекторын 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн шийдвэрийн дагуу олгосон АТД-22-24/23 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавартай, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/106 дугаар шийдвэрээр Сүхбаатар аймгийн Уулбаян сумын 2 дугаар баг, Зүүнбулэг 6 дугаар хаягт байрлах 2213000638 нэгж талбарын дугаартай 1205 мкв газрыг Банк, санхүүгийн байгууллага зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэх эрх олгосон Э-1210000040 дугаар гэрчилгээтэй, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эм Эс Ки энд Ти У ХХК-ын 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн дулаан хангамжийн техникийн нөхцөлтэй, "Инженер геодези" ХХК-ийн 2023 онд барилгын талбайд хийсэн инженер геологийн судалгааны дүгнэлттэй барилга байна. Дүгнэлтээр тус барилгажих талбай нь инженер-геологийн "Хүнд" нөхцөлд хамаарахаар судлагдсан.

Уг барилгын нийт эзлэхүүн 400м^3, барилгажих нийт талбай 172м^2, 9х10м хэмжээтэй зоорьгүй, нэг давхар барилга ба нэгдүгээр давхарт гүйлгээний танхим, гонх, сейфны өрөө, теллерийн хэсэг, ариун цэврийн өрөө, архивийн өрөө, техникийн өрөө, захирлын өрөө, харилцааны менежерийн өрөө байхаар;

Гаднаа 13 автомашины зогсоолтой, гадна талбайг зүлэг, тармил ургамлаар тохижуулахаар;

Халаалт нь төвлөрсөн системээс хангахаар;

Цэвэр усны эх үүсвэр нь тухайн сумыг төвлөрсөн системд холбогдох хүртэл зөөврийн усан хангамжтай байх ба нөөцийн саваар дамжуулан агшин зуурын ус халаагчаар халаахаар;

Бохир усыг зайлуулах дотор бохир усны системийг байгуулах ба нэгдсэн бохир усны шугам сүлжээ ашиглалтад орох хүртэл түр стандартын шаардлага хангасан нүхэн жорлонтой байхаар;

Агаар сэлгэлт нь сорох механик системээр, 1 дугаар давхарт ЕС-1-4 ердийн системээр сэлгэхээр тус тус төлөвлөсөн байна.

Хоёр. Дүгнэлт

"Эрүүл ахуйн тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийг үндэслэн ДҮГНЭХ НЬ:

14252546

Сүхбаатар аймгийн Уулбаян суманд баригдах Төрийн банкны тооцооны төвийн барилгын ажлын зураг нь “Олон нийт, иргэний барилга /БНбД 31-03-03*/11/ норм ба дүрэм бусад холбогдох стандартын шаардлага хангаж байна.

Энэхүү барилга байгууламжийг цэвэр бохир усны нэгдсэн сүлжээнд холбогдох хүртэл нөөцийн сав, нүхэн жорлонгийн цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтэд онцгой анхаарч, ажиллах шаардлагатай.

Дээрх барилгын ажлын зурагт гаргасан энэхүү эрүүл ахуйн дүгнэлт нь Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын даргын гарын үсэг зурж баталгаажсан нүүр хуудас болон Улсын ахлах байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулсан хуудасны хамт хүчин төгөлдөр байна.

Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу удирдах албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Г.ЦОЛМОНБАЯР

ХҮЛЭЭН АВСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.БАТЦЭНГЭЛ